



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 34

Есөнбулаг сум

"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах"  
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Ж" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах" аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах" аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн эцэст ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
04 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр  
тогтоолын 1-р хавсралт



## “ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хүн амын дунд сүүлийн 20 гаруй жил шалтгаан нь нийтлэг, урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой Халдварт бус өвчин/цаашид ХБӨ гэх/ зонхилж, үр бүтээлтэй ажиллах чадамжтай хөдөлмөрийн насныхны дунд ихэвчлэн тохиолдож байгаа нь манай салбарын нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болсоор байна.

-ДЭМБ-ын ХБӨ-өөс сэргийлэх стратеги төлөвлөгөө, зөвлөснөөр ХБӨ түүнд нөлөөлөх шалтгааныг хяналтанд авч тодорхой арга хэмжээ авбал энэ өвчнөөр өвчлөх, цаг бусаар нас барах, тахир дутуу болох тохиолдлыг 50%, үүнээс зүрх судасны өвчнийг 80%, чихрийн шижин хэвшинж-2-ыг 90 хүртэл хувь, хавдрын тохиолдлыг 30% гаруй бууруулах боломжтой гэж үздэг.

Сүүлийн 3 жилийн байдлаар аймгийн хүн амын нас баралтын шалтгааны 86.9 хувийг ХБӨ эзэлж, үүний дотор 2 хүний нэг нь зүрх судасны тогтолцооны өвчин, 3 хүний нэг нь хавдар, 7 хүний нэг нь гэмтэл хордлого, гадны шалтгааны улмаас нас барж байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар манай аймагт 329 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдснээс 154 буюу 46,8 хувийг элэгний хорт хавдар эзэлж байгаа бөгөөд шинээр илэрсэн хүмүүсийн 44 буюу 28,6 хувь нь 1,2-р шатандаа, 110 буюу 71,4 хувь нь 3,4-р шатандаа хожуу оношлогдсон. Хорт хавдраар нас барсан 247 хүний 124 буюу 50,2 хувь нь элэгний хорт хавдрын улмаас нас барсан байна.

Хүн амын 2013 оны судалгааны дүнгээр 4 хүн тутмын 1 нь хөдөлгөөний хомсдолтой, 38,9% нь илүүдэл жин, таргалалттай, тамхины хэрэглээ 26,7%, архины хэрэглээ 35,1%, харин давсны хэрэглээ 2 дахин их байна. Цусны даралт ихдэх өвчин-27,5, цусандах сахарын өөрчлөлттэй хүн амын тархалт 8,3%, сахар бууруулах эм хэрэглэж буй хүн амын тархалт 6,9%, хорт хавдар хүн амын нас баралтын шалтгааны 22%-ийг эзэлж байна.

Манай аймагт 2013 оны түүвэрчилсэн судалгаагаар хүн амын тамхины хэрэглээ 26,74, архины хэрэглээ 35,1%, давсны хэрэглээ 1 хүн хоногт 7,20, илүүдэл жинтэй хүмүүсийн эзлэх хувь 38,9 бөгөөд ойрын жилүүдэд энэ чиглэлийн судалгаа хийгдээгүй болно.

Түүнчлэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бөөрний хурц болон архаг үрэвсэлт өвчин эхний байранд орж байгаа нь бөөрний архаг дутагдалтай өвчтөний тоо жилээс жилд нэмэгдэхэд хүргэж, улмаар өндөр өртөгтэй гемодиализ болон бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ шаардагдахаар байна. Өнөөдрийн байдлаар гемодиализийн эмчилгээнд 8 хүн орж байгаа бөгөөд төлбөрийг нь төрөөс шийдэж байна.

Халдварт бус өвчний суурь шалтгаан болох шүд, гүйлсэн булчирхайн үрэвсэл, нүдний хараа, сонсголын эмгэгийн тархалт хүүхдүүдийн дунд их байна. Тухайлбал, өсвөр үеийнхний 70 гаруй хувь нь шүд хорхойтсон, жилдээ хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн 10 хувь нь гүйлсэн булчирхайн үрэвсэлтэй, жилдээ амбулаториор үзүүлж буй хүний 14-16 хувь нь харааны ямар нэг эмгэгтэй хүүхдүүд эзэлж байна.

Суурин газрын хүн амын дунд шарилж, лууль болон бусад хөл газрын ургамлын цэцгийн тоосны шалтгаант амьсгалын замын харшил түгээмэл ихсэх хандлагатай байна. Аймгийн түвшинд харшилтай хүмүүсийн судалгаа хийгдээгүй ба цаашид мэргэжлийн хүмүүсийн мэдлэг чадварыг дээшлүүлж, анхаарал хандуулах шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах чиглэлээр олсон ололтоо бататгах, байгууллага, хамт олон, нийгмийн салбар, олон улсын байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын оролцоонд тулгуурлан ХБӨ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг үндэслэн ХБӨ-өөс сэргийлэх, хянах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулав.

1.2.Хөтөлбөрийн хамрах хүрээнд хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох хувийг эзэлдэг, урьдчилан сэргийлэх боломжтой ХБӨ болох зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, бөөр, уушгины архаг бөглөрөлт өвчин, хоол боловсруулах замын өвчин, яс, булчин, үе мөчний өвчин, сэтгэцийн өвчин, тэдгээрийн анхдагч шалтгаан болох тамхи, архины хортой хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, уур бухимдал, халдварын бус гаралтай харшил болон зайлсхийж болох сохрол, дүлийрлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах асуудал орно.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа, зарчим

2.1.Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олны хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах замаар өвчлөл, нас баралтыг бууруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олны хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах

Зорилт 2.ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах замаар өвчлөл, нас баралтыг бууруулах

2.3.Хөтөлбөрийг 2017-2021 онд дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

I үе шат: 2017-2019 он;

II үе шат: 2020-2021 он.

2.4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

2.4.1.Засгийн газрын үйл ажиллагаа, үндэсний бусад хөтөлбөр, олон улсын байгууллагын зорилттой уялдсан, нэгдмэл байх

2.4.2. Аймгийн ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлтэй уялдсан байх

2.4.3. Иргэд хамт олны дунд эрүүл аж төрөх зан үйл төлөвшихөд дэмжлэг үзүүлэхүйц орчин бүрдүүлэх, ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах ажлыг салбар дундын ажиллагаанд тулгуурлах

2.4.4. Иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангах

2.4.5. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн бусад хөтөлбөр төслүүдтэй нягт уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх

Гурав.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1.Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн арга зүйч,нийгмийн ажилтан, эрүүл мэндийн хичээлийн багш,эмч нарыг халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн талаар чадавхжуулах, хамтран ажиллах

3.1.2. Анагаах ухааны сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дунд зонхилон тохиолдох өвчлөл,архаг халдварын голомт, хараа сулрал, илүүдэл жин, таргалалт, сэтгэц, зан төлөвийн тулгамдсан асуудлын түвшинг тогтоож, мэдээллээр хангах

3.1.3. Анагаах ухааны салбар сургуулийн сургалтын хөтөлбөрт зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах, хамтран ажиллах

3.1.4.Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар иргэд, шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлагыг сайжруулах, нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

3.1.5. Архи, тамхи, бусад зүйлд донтох, чихэрлэг хүнс зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг бууруулах, сэргийлэх олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг түшиглэн явуулах, иргэдэд архи,тамхинаас татгалзах хүсэл төрүүлэх, хорт зуршлыг хаях зан үйлийг төлөвшүүлэх ажил зохион байгуулах;

3.1.6.Согтууруулах ундааны хортой хэрэглээ түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах талаар бусад салбаруудтай хамтран ажиллах

3.1.7. Архины хортой хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих;

3.1.8. Байгууллага бүр ажиллагсдынхаа бие бялдрын хөгжлийн түвшин, биеийн жингийн индекс, хөдөлгөөний хомсдол, цусны даралт ихсэх, чихрийн шижингийн хэв шинж-2, бөөр, хөх, умайн хүзүү, элэг, ходоодны хавдар зэрэг өвчнийг эрт илрүүлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулж хүн бүрийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, эрүүлжүүлэх, хянадаг нэгдсэн мэдээлэлтэй болох

3.1.9. Олон нийтийн дунд зохистой хооллолт хөдөлгөөний идэвх нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, үнэлгээ хийх

3.1.10. Хүн амын дунд зонхилж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, уур бухимдал, сэтгэл гутрал, стрессээс сэргийлэх зөвлөмж, мэдээллийг олон нийтэд системтэй хүргэх

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. Явуулын амбулаторийн үзлэгийн чанар, хүртээмж, халдварт бус өвчний эрт илрүүлэхэд шаардагдах эм, урвалж, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн дэмжлэг, хамтын ажиллагааг сайжруулах

3.2.2.Түргэвчилсэн оношилгоо хийх мобайл технологийг нэмэгдүүлэх

3.2.3.ХБӨ-өөс сэргийлэх, эмчлэх, хянах ажлыг эрхэлдэг эмч, эрүүл мэндийн мэргэжилтнийг сургалтад тогтмол хамруулах замаар мэдлэг, мэргэжлийг нь дээшлүүлэх

3.2.4.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хүлээх үүрэг, хариуцлага, ажлын уялдаа холбоог сайжруулах, өвчтөн шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох цахим сүлжээг боловсронгуй болгох;

Дөрөв.Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт	
			2019 он	2021 он
А.Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:				
I.Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт:				
1.	Хүн амын тамхины хэрэглээ, хувиар	27.1	26.5	25.5
2.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн13-15 насны хүүхэд, хувиар	5.9	5.4	4.9
3.	Сүүлийн 30 хоногт тамхийг 1-2 удаа хэрэглэсэн 16-17 насны хүүхэд, хувиар	17.5	17.5	14.5
4.	Сүүлийн 30 хоногт ажлын байрандаа тамхины утаанд өртөгсөд, хувиар	25.5	23.4	21.3

5.	15-аас дээш насны нэг хүнд ногдох бүртгэгдсэн согтууруулах ундаа, литр (архинд шилжүүлснээр)	9.8	7.0	6.9
6.	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгчид, хувиар	25.3	18.0	15.6
7.	Согтууруулах ундааг 1-2 удаа хэтрүүлэн хэрэглэж үзсэн сурагчид, 15-17 нас, хувиар	23.1	22.3	21.6
8.	25-64 насны хүн амын давсны хоногийн дундаж хэрэглээ (гр/хоног)	11.1	10.0	8.9
10	Хөдөлгөөний хомсдолтой хүн ам, хувиар	22.3	19.6	18.8
<b>II.Халдварт бус өвчний завсрын эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт:</b>				
1	Илүүдэл жин, таргалалттай хүн амын эзлэх хувь (БЖИ $\geq 25\text{кг/м}^2$ )	54.4	48.9	45.5
2	Цусны даралт ихсэлт (артерийн дээд даралт $\geq 140$ , доод даралт $\geq 90$ ба даралт бууруулах эм хэрэглэж байгаа)-ийн тархалт, хувиар	27.5	25.2	22.9
3	Цусан дахь нийт холестерин хэмжээ 5 ммол/л ба түүнээс их хүн амын эзлэх хувь	61.9	56.7	51.9
4	Цусан дахь глюкозын хэмжээ ихэссэн (6.1 ммол/л ба түүнээс их), глюкоз бууруулах эм хэрэглэж байгаа хүн ам, хувиар	8.3	6.3	5.8
<b>III.Халдварт бус өвчний эрт илрүүлэлт, өвчлөлийн үзүүлэлт</b>				
1	Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (30-60 нас)	57.8	70.0	90.0
2	Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, бодит тоо (30-60 нас)	6805	7000	8000
3	Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-65 нас)		50.0	70.0
4	Элэгний хорт хавдар эрт үе шатандаа оношлогдсон хувь(I,II үеийн эзлэх хувь)	26.1	27.0	28.0
5	Умайн хүзүүний хорт хавдар эрт үе шатандаа оношлогдсон хувь (I үеийн эзлэх хувь )	25.0	60.0	70.0
6	Цусны даралт ихсэх өвчинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас)	57.6	70.0	90.0
7	Чихрийн шижинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас)	56.4	70.0	90.0
<b>Б.Хөтөлбөрийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:</b>				
1	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд)	16.2	15.0	10.5
2	Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт (10000 хүн амд)	23.4	23.1	22.5
3	Бөөрний сувганцрын үрэвсэлт өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч, хувиар		15.0	14.5

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
04 дүгээр сарын 29-ны өдрийн 39 дүгээр  
тогтоолын 2-р хавсралт

ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа	Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилт (мян. төг)
Зорилт 1. Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олны хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах							
1	3.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн арга зүйч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн хичээлийн багш, эмч нарыг халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн талаар чадавхжуулах, хамтран ажиллах	ЭМГ, БСУГ	ЕБС, СӨБ	2018-2020	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн дундах өвчлөлийн түвшинг тогтоож жил бүр суурь түвшингээс бууруулсан байна.	Холбогдох мэргэжилтнүүдийн 90-ээс доошгүй хувийг хамруулна	Улсын төсөв 24.000.0
2	3.1.2. Анагаах ухааны сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дунд зонхилон тохиолдох өвчлөл, архаг халдварын голомт, хараа сулрал, илүүдэл жин, таргалалт, сэтгэц, зан төлөвийн тулгамдсан асуудлын түвшинг тогтоож, мэдээллээр хангах	Нэгдсэн эмнэлэг, өрхийн ЭМТ-үүд	ЭМГ, АУС, МСҮТ	2018	Өвчлөл, эрсдэлт хүчин зүйлийн түвшин тогтоож, жил бүр бууруулсан байна.	Хамрагдсан зохих оюутнууд, суралцагчдын 70-аас доошгүй хувийг хамруулна.	Улсын төсөв
3	3.1.3. Анагаах ухааны салбар сургуулийн сургалтын хөтөлбөрт зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах, хамтран ажиллах	Аймгийн Анагаахын салбар сургууль	ЭМГ	2018-2019	Төгссөн эмнэлгийн мэргэжилтий мэдлэг, үр чадвартай болно.	Хөтөлбөрт тусгах шийдвэр гарсан байна	Улсын төсөв
4	3.1.4. ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар иргэд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлагыг сайжруулах, нийтэд чиглэсэн	ЭМГ, НЭ	Аймаг, сумын ЗДТГ	2018-2021	ХБӨ-ий анхдагч болон завсрын 14 эрсдэлт хүчин зүйлийг суурь	Иргэдийн 70%, удирдах ажилтны 50-аас доошгүй	Улсын төсөв 4.000.0

	мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.				түвшингээс бууруулсан байна.	хувийг хамруулна.	
5	3.1.5.Архи, тамхи зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг бууруулах, сэргийлэх олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг түшиглэн явуулах, иргэдэд архи,тамхинаас татгалзах хүсэл төрүүлэх, хорт зуршлыг хаях зан үйлийг төлөвшүүлэх ажил зохион байгуулах	Аймаг, сумын ЗДТГ, ЭМТ	ЭМГ, Цагдаагийн газар	2018-2020	Архи, тамхины хэрэглээ өмнөх оноос буурсан байна.	Зорилтот бүлгийн дунд сар үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.	Улсын төсөв 4.000.0
6	3.1.6. Согтууруулах ундааны хортой хэрэглээ түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах талаар бусад салбаруудтай хамтран ажиллах	Аймаг, сумдын ИТХ, ЗДТГ Цагдаагийн газар	ЭМГ, ЭМТ-үүд	2018-2021	Согтуугаар үйлдэгдсэн зөрчил, осол өмнөх оноос буурна.	Цагдаагийн байгууллага тай хамтран улирал тутам нөлөөллийн ажил хийсэн байна.	Орон нутгийн төсөв 4.000.0
7	3.1.7.Согтууруулах ундааны хор хөнөөл, нийгмийн сөрөг үр дагаврын талаар хүүхэд өсвөр үе, залуучууд, төрөх насны эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн иргэд зэрэг эрсдэл ихтэй хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах	Сум, өрхийн ЭМТ-үүд	ЭМГ, БСУГ	2018-2021	Согтууруулах ундааны хэрэглээ буурна.	Зорилтот бүлгийн хүн амын 70-аас доошгүй хувийг хамруулна.	Эрүүл мэндийг дэмжих сан 4.000.0
8	3.1.8.Согтууруулах ундааны хортой хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавраас нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах талаар эрүүл мэнд хууль хяналтын байгууллагын хамтарсан зөвлөгөөн, сургалт зохион байгуулах	Эрүүл мэндийн байгууллагууд	Цагдаагийн газар	2018-2021	Архины хэрэглээний түвшин буурна.	Зөвлөгөөн 1 удаа, сургалтыг жил бүр зохион байгуулна.	Орон нутгийн төсөв 6.000.0
9	3.1.9.Архины хортой хэрэглээ, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулахаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих	ЭМГ	ТББ	2018-2021	Архинд донтох эмгэгтэй хүний тоог бууруулсан байна.	ТББ-тай хийсэн гэрээ, санхүүжилт, хэрэгжилт	Орон нутгийн төсөв 1.000.0